



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар Б/44

Хэрлэн сум

Ж.Энх-Амгаланд сахилгын
шийтгэл ногдуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.15 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ноогдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 1.4, 1.5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.1. заасан арга хэмжээний Атарын 4 дахь аян, тариалангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулаагүй, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн тайлан, өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн нь тогтоогдсон тул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Жонийн Энх-Амгаланд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ